

**2024 ОНЫ 02 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 03 дугаар сарын 06-ны “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СУРГАЛТЫН ЧАНАР, СТАНДАРТ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
1	Боловсролын салбарын сургалтын чанар, стандартыг бодлогын түвшинд сайжруулах, хүний хөгжлийг хангах чиглэлээр хөтөлбөр боловсруулж танилцуулах.	НХХ, БХ
2	Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийг хичээлдээ сонирхолтой болгох зорилгоор Улаанбаатар хотын түүх, соёлын дурсгалт газруудад очиж танилцах, түүхийн хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж танилцуулах.	
3	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгтэй холбоотой сүүлийн 5 жил болон 2024-2028 он хүртэлх урьдчилсан статистик тоон мэдээллийг гаргаж танилцуулах.	НХХ, БХ, Статистикч
4	Нийслэлийн (дүүргийн) хөгжлийн бодлого, төлөвлөлтийн 2025, 2026, 2027 оны төсөөллийг боловсруулах.	ЗДО Б.Болормаа
ТОХИЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД		
5	“Тохижилт бүтээн байгуулалтын жил”-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг нийслэл болон дүүргүүдэд хийх тохижилтын ажлуудтай уялдуулан боловсруулж танилцуулах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ
6	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс барилга, угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг сайтар хангах.	НХХ, Холбогдох байгууллагууд
7	Нийслэлийн хэмжээнд газрын хэмжээгээ хэтрүүлэн хашаалсан иргэн, аж ахуйн нэгжийн нарийвчилсан судалгааг гарган, зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулах.	ГЗБА
БУСАД ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
8	Дүүргийн хэмжээнд гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр ажлуудыг зохион байгуулах	Цагдаагийн хэлтэс, ГХУСАЗСЗ
9	Барилга угсралтын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, барилгын норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулж, орчин тойрны өнгө үзэмжийг сэргээлгэх ажлыг зохион байгуулах.	ТХҮХ, ХХҮХ
10	Шар усны үер болон хөрсний ус, халиа дошингоос урьдчилан сэргийлэх, үүссэн нөхцөл байдлыг шуурхай арилгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, далан сувгийн цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлэх.	ТХҮХ, ОБХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
11	Газар хөдлөлт, гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлэн байдлын сургалтыг 2024 оны	ОБХ

	04 дүгээр сард зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангах.	
12	“UB-engineering” буюу Хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналтын системийн мэдээллийг шинэчлэх, хэрэгжилтийн явцын талаар нийслэлийн Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах тул холбогдох мэдээллийг хүргүүлэх.	ТХҮХ
13	Авто замын тэмдэг, тэмдэглэгээг шинээр байршуулах, сэргээн засварлах ажлуудыг зохион байгуулж дуусгах.	ЦХ-ийн ЗЦХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
14	Албан тушаалтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах, ажлын байранд архидан согтуурахгүй байх, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулах, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах.	Нийт байгууллагууд
15	Нийслэлийн төсвийн орлогыг нэмэгдүүлж, орлогын эх үүсвэрийн бааз суурийг өргөтгөх ажлын талаар санал боловсруулж танилцуулах.	СТСХ, Татварын хэлтэс
16	Нийслэлийн хэмжээнд мал, нохой, муур гаргах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах.	ЗДО Б.Болормаа ТХҮХ (ХААТ)
17	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулах ажлыг эрчимжүүлэх.	Ажлын хэсгийн гишүүд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
18	УОК болон Нийслэлийн Онцгой комисстой хамтран дүүрэгт өвс тэжээл хуваарилуулан авах ажлыг эрчимжүүлэх.	ДОК, ОБХ
19	2024 оныг дүүргийн хэмжээнд “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан нээлтийн арга хэмжээг 03 дугаар сарын эхний 10 хоногт багтаан зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан бэлтгэлийг сайтар хангаж, энэ хүрээнд холбогдох уулзалтуудыг зохион байгуулах.	ЗДТГ, ААНБ-ууд
20	2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр дүүрэгт зохион байгуулагдах УИХ-ын гишүүний уулзалтын бэлтгэлийг сайтар хангаж иргэд, ажилтан, албан хаагчдыг идэвхтэй оролцуулах.	Нийт байгууллагууд
21	Сар бүрийн эхний 7 хоногийн “Даваа” гарагт үндэсний уламжлалаа хадгалах, Монгол дээл, хувцсаар гоёх “Монгол гоёлын өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулах тухай ДИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах.	Нийт байгууллагууд
22	Малын сэг зэмийг устгах, ариутгах ажлыг зохион байгуулах талаарх тооцоолол, төлөвлөгөө гарган танилцуулах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ, МЭТ, “Цеф трэйд” мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
23	Нийслэлийн хэмжээнд байгаа камерыг шинэчлэх, мэдээлэл байршлуудыг нэгтгэх хүрээнд нийслэлийн Шуурхай удирдлагын төвийн мэдээлэлтэй танилцан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	ТХҮХ, Цагдаагийн хэлтэс, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
24	2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдах “Монгол Цэргийн баяр”-ын өдрийн арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэлийг ханган холбогдох арга хэмжээг чанартай зохион байгуулахад анхаарах.	Цэргийн штаб, ААНБ-ууд

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР